



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/693

Булган сум

**Захирамжинд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан “Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах” зардлын хуваарийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2.Хавсралтаар батлагдсан зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг холбогдох норм дүрмийн дагуу боловсруулж, батлуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг хууль, журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөл, ТЭЗҮ боловсруулах зардлын хуваарь

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртгөр /төгрөг/ 2023 онд санхүүжих дүн	Тайлбар
1	Баян-Агт сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөв	1,980,000	2022 оны гэрээний үлдэгдэл санхүүжилт
2	Булган сумын 4 дүгээр багт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	5,970,000	2022 оны гэрээний үлдэгдэл санхүүжилт
3	Засаг даргын тамгын газрын конторын барилгын холболтын зураг /Хишиг-Өндөр сум/	8,945,060	2022 оны гэрээний үлдэгдэл санхүүжилт
4	Аймгийн Бизнес хөгжлийн төвийн барилгын зураг төсөв	40,500,000	2022 оны гэрээний санхүүжилт
5	Инженер геологийн судалгаа	29,590,997	2022 оны гэрээний үлдэгдэл санхүүжилт
6	Булган сум 2,6 дугаар баг миний голомтын уулзвараас ОБГ хүртлэх үерийн байгууламжийн засварын зураг төсөв	37,000,000	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
7	Булган сумын 2,3,5 дугаар багийн гэр хорооллын гэрэлтүүлгийн ажлын зураг төсөв	15,245,846	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
8	Булган сумын 5 дугаар баг 11,16,17,19,104 дүгээр байрны гадна фасадны зураг төсөв	20,000,000	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
9	ЭӨЦС-аас 2-р цэцэрлэг хүртэлх дулааны шугамын өргөтгөл, хэрэгцээний халуун усны шугамын зураг төсөв	50,000,000	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
10	Булган сумын 2-р цэцэрлэгийн барилгын засварын зураг төсөв	18,000,000	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
11	Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд 500 тн-ийн механикжсан зоорын зураг төсөв	70,000,000	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
12	Тэшиг сумын Соёлын төвийн барилгын их засвар зураг төсөв	16,676,397	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
13	Хялганат тосгоны соёлын төвийн барилгын зураг төсөв	20,000,000	Холболтын зураг хийлгэнэ.
14	Сайхан сумын Соёлын төвийн барилгын их засвар зураг төсөв	15,000,000	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
15	Аймгийн төвийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийн хэмжээг нэмэгдүүлэх ажлын зураг төсөв	56,500,000	АЗД-ын 2022 оны а/590 дүгээр захирамжийн дагуу санхүүжүүлэх
16	Жаргалант зуслангийн инженерийн шугам сүлжээ зураг төсөв	60,000,000	АЗД-ын 2022 оны а/590 дүгээр захирамжийн дагуу санхүүжүүлэх
17	Жаргалант зуслангийн уран тогоо	35,000,000	АЗД-ын 2022 оны а/590 дүгээр

	хотхон		захирамжийн дагуу санхүүжүүлэх
18	Жаргалант зуслангийн олимп хотхон	40,000,000	АЗД-ын 2022 оны а/590 дүгээр захирамжийн дагуу санхүүжүүлэх
19	Жаргалант зуслангийн сансар хотхон	35,000,000	АЗД-ын 2022 оны а/590 дүгээр захирамжийн дагуу санхүүжүүлэх
20	Хутаг-Өндөр сумын Дондогийн булагийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	70,000,000	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
21	Сэлэнгэ мөрний гүүрний орчимд голын урд салааны урсацын зохих хэсгийг хойд салаанд шилжүүлэх балансын тохируулга хийх зураг төсөв	70,000,000	АЗД-ын 2022 оны а/266 дугаар захирамжийн дагуу санхүүжүүлэх
22	Аймгийн ЗДТГ-ын Б,В блокийн дээврийн их засварын зураг төсөв	19,000,000	АЗД-ын 2023 оны а/627 дугаар захирамжийн дагуу санхүүжүүлэх
23	Аймгийн ЗДТГ-ын Г блокийн зоорины давхарын дахин төлөвлөлтийн засварын зураг төсөв	19,900,000	АЗД-ын 2023 оны а/628 дугаар захирамжийн дагуу санхүүжүүлэх
24	Аймгийн ЗДТГ-ын фасадын шинэчлэлийн зураг төсөв	19,900,000	АЗД-ын 2023 оны а/629 дүгээр захирамжийн дагуу санхүүжүүлэх
25	Аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилгын төсөв шинэчлэх	14,410,440	ТБОНХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтын дагуу
26	Зураг төсөв боловсруулахад шаардагдах техникийн нөхцөлийн зардал	6,854,060	Зураг төсвийн гэрээний 2022 оны үлдэгдэл санхүүжилт
Нийт дүн		795,472,800	